

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/111-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2026 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn Аудитор: Ж.Цогт Утас: 7036-3047 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn
---	--



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОНЦГОЙ
БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА
С.ПҮРЭВСАМДАН ТАНАА

2026.02.11 № СЭА-2026/111-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд аймгийн хэмжээнд 2025 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс 08 дугаар сарын 06-ны өдрийн хооронд ойн сан бүхий 11 сумын нутагт нийт 97 удаагийн ой, хээрийн түймрийн дуудлага бүртгэгдэж, түймрийг унтраах ажиллагаанд Онцгой байдлын байгууллагын 2576 албан хаагч, 200 автомашин ашиглагдаж томилолтын зардалд 682,847.5 мянган төгрөгийг, хоол, хүнсний зардалд 28,736.5 мянган төгрөгийг, шатахууны зардалд 139,127.9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

ОБЕГ-аас стандарт, мэдээллийн технологийн шинэчлэлт хийснээр тайлант онд тус аймагт бүртгэгдсэн түймрийн 65.9 хувийг *firms.modaps.eosdis.nasa.gov.com*, *icc.mn* болон бусад түймрийн дулааны цэг илрүүлэх сайтаар илрүүлж, шуурхай арга хэмжээг авч ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Онцгой байдлын газар нь тайлант онд “Онцгой байдлын үйл ажиллагаанд стандарт, мэдээллийн технологийн шинэчлэлт хийж, гамшгийн удирдлагын нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэх, алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй аюулгүй ажиллагааг хангах, сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх” зорилго дэвшүүлж, 2 зорилт, 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 86.8 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		2,975,578,514.5	3,283,106,442.4
33	АВЛАГА	5	9,560,500.0	4,738,765.5
33300	Татаас, санхүүжилтийн авлага		9,560,500.0	1,980,000.0
33500	Бусад авлага		-	2,758,765.5
33510	Байгууллагаас авах авлага		-	2,758,765.5
34	УРЬДЧИЛГАА	6	744,480.0	744,480.0
34600	Урьдчилж гарсан зардал		744,480.0	744,480.0
35	БАРАА МАТЕРИАЛ	7	2,965,273,534.5	3,277,623,196.9
35100	Түүхий эд материал		1,842,867,757.5	1,905,365,121.2
35110	Тусгай зориулалттай материал		1,842,143,207.5	1,886,760,571.2
35130	Эм боох материал		724,550.0	18,604,550.0
35400	Хангамжийн материал		1,120,891,277.0	1,370,743,575.7
35410	Бичиг хэргийн материал		5,370,525.0	10,068,425.0
35420	Аж ахуйн материал		39,627,660.0	39,897,660.0
35430	Сэлбэг хэрэгсэл		112,388,033.0	121,656,837.1
35440	Түлш, шатах тослох материал		77,570,760.6	68,299,208.8
35450	Барилгын засварын материал		32,500,000.0	41,700,974.7
35470	Бусад хангамжийн материал		853,434,298.4	1,089,120,470.2
35600	Мал амьтад		1,514,500.0	1,514,500.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		9,149,689,238.7	10,357,174,737.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8	9,149,689,238.7	10,357,174,737.0
39200	Биет хөрөнгө		8,200,363,638.7	9,359,944,137.0
39201	Барилга, байгууламж, орон сууц		6,983,466,457.3	6,992,963,957.3
39202	Хуримтлагдсан элэгдэл		(1,414,053,928.4)	(1,605,777,281.5)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		8,379,415,516.1	10,345,415,516.1
39204	Хуримтлагдсан элэгдэл		(6,362,923,344.0)	(7,360,493,466.6)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)		2,500,556,995.5	2,895,411,487.2
39206	Хуримтлагдсан элэгдэл		(1,915,371,267.1)	(2,067,884,428.8)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		178,341,466.3	195,986,766.3
39208	Хуримтлагдсан элэгдэл		(151,648,160.3)	(156,563,396.1)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж		15,190,000.0	15,190,000.0
39212	Хуримтлагдсан элэгдэл		(14,695,000.0)	(15,190,000.0)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс		-	19,850,000.0
39214	Бусад үндсэн хөрөнгө		26,644,050.1	26,644,050.1
39215	Хуримтлагдсан элэгдэл		(24,559,146.9)	(24,884,067.0)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		-	99,275,000.0
39300	Биет бус хөрөнгө		949,325,600.0	997,230,600.0
39303	Бусад биет бус хөрөнгө		949,325,600.0	997,230,600.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		12,125,267,753.2	13,640,281,179.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9	-	2,758,765.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		-	2,758,765.5
41300	Өглөг		-	2,758,765.5
41360	Бусад өглөг		-	2,758,765.5
41361	Байгууллагад төлөх өглөг		-	2,758,765.5

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		12,125,267,753.2	13,637,522,413.9
51	Засгийн газрын хувь оролцоо		12,125,267,753.2	13,637,522,413.9
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,892,403,369.3	1,892,403,369.3
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		1,892,403,369.3	1,892,403,369.3
51200	Хуримтлагдсан үр дүн		4,034,738,900.2	5,546,993,560.9
51210	Өмнөх үеийн үр дүн		3,071,029,684.3	4,034,738,900.2
51220	Тайлант үеийн үр дүн		963,709,216.0	1,512,254,660.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		6,198,125,483.7	6,198,125,483.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		12,125,267,753.2	13,640,281,179.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2	9,803,053,776.8	13,638,200,719.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		2,463,519,833.8	13,638,200,719.6
120	Нийтлэг татварын бус орлого		2,463,519,833.8	4,509,066,116.9
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		1,346,362,228.5	2,339,237,191.7
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		1,117,157,605.3	2,169,828,925.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		7,339,533,943.0	9,129,134,602.7
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		6,873,519,800.0	8,109,234,700.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		6,873,519,800.0	8,109,234,700.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		466,014,143.0	1,019,899,902.7
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		228,871,263.0	163,106,842.5
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		214,955,500.0	856,793,060.2
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		22,187,380.0	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	8,824,624,560.8	12,145,259,958.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ		8,824,624,560.8	12,145,259,958.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		8,801,377,568.2	12,128,166,858.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		5,931,303,980.0	6,981,243,214.0
210101	Үндсэн цалин		3,582,770,335.0	4,269,937,727.0
210102	Нэмэгдэл		2,165,291,195.0	2,359,742,987.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт		78,107,000.0	103,508,000.0
210104	Урамшуулал		105,135,450.0	248,054,500.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		149,386,228.5	168,186,384.0
210201	Тэтгэврийн даатгалын зардал		25,820,524.0	26,429,834.0
210202	Тэтгэмжийн даатгалын зардал		3,037,709.0	3,109,392.0
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал		1,479,255.0	1,551,395.0
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал		1,316,050.0	1,269,717.0
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал		117,732,690.5	135,826,046.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		365,643,138.0	466,577,206.8
210301	Гэрэл, цахилгаан		73,377,547.2	92,522,163.8
210302	Түлш, халаалт		241,461,540.8	324,577,571.0
210303	Цэвэр, бохир ус		50,804,050.0	49,477,472.0
2104	Хангамж, бараа материалын зардал		222,802,768.6	304,933,402.0
210401	Бичиг хэрэг		6,125,600.0	2,732,400.0
210402	Тээвэр, шатахуун		210,888,382.1	295,935,669.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		2,533,846.5	3,442,993.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		240,000.0	2,822,340.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3,014,940.0	-

2105	Нормативт зардал		490,293,012.6	693,854,469.7
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		2,262,200.0	16,380,000.0
210502	Хоол, хүнс		275,886,197.6	282,890,949.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		212,144,615.0	394,583,520.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		268,369,200.0	71,944,300.0
210604	Урсгал засвар		268,369,200.0	71,944,300.0
2107	Томилолт, зочны зардал		68,548,500.0	693,975,865.5
210701	Гадаад албан томилолт		-	11,128,365.5
210702	Дотоод албан томилолт		68,398,500.0	682,847,500.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		150,000.0	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		24,072,216.7	26,540,932.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		17,398,500.0	16,597,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар		3,005,338.7	4,221,932.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		2,090,000.0	2,266,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		891,000.0	1,943,700.0
210807	азрын төлбөр		687,378.0	1,512,300.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,280,958,523.7	2,720,911,084.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		170,389,811.4	1,349,409,291.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		8,350,460.0	23,960,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		1,102,218,252.4	1,347,541,793.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		23,246,992.6	17,093,100.5
2132	Бусад урсгал шилжүүлэг		21,350,000.0	8,434,000.0
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		-	3,050,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		21,350,000.0	5,384,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,896,992.6	8,659,100.5
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,896,992.6	8,659,100.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		978,429,216.0	1,492,940,760.7
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		-	19,313,900.0
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз		-	19,313,900.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		14,720,000.0	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		14,720,000.0	-
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		(14,720,000.0)	19,313,900.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		963,709,216.0	1,512,254,660.7

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	7,349,533,943.0	9,135,936,337.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,349,533,943.0	9,135,936,337.2
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,873,519,800.0	8,109,234,700.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,873,519,800.0	8,109,234,700.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	476,014,143.0	1,026,701,637.2
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	228,871,263.0	160,348,077.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	214,955,500.0	856,793,060.2
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	32,187,380.0	9,560,500.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,288,333,743.0	8,922,905,002.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,288,333,743.0	8,922,905,002.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,255,526,250.4	8,888,410,302.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,931,303,980.0	6,981,243,214.0

210101	Үндсэн цалин	3,582,770,335.0	4,269,937,727.0
210102	Нэмэгдэл	2,165,291,195.0	2,359,742,987.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	78,107,000.0	103,508,000.0
210104	Урамшуулал	105,135,450.0	248,054,500.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,386,228.5	168,186,384.0
210201	Тэтгэврийн даатгалын зардал	25,820,524.0	26,429,834.0
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	3,037,709.0	3,109,392.0
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	1,479,255.0	1,551,395.0
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	1,316,050.0	1,269,717.0
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	117,732,690.5	135,826,046.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	372,083,438.0	452,959,186.8
210301	Гэрэл, цахилгаан	73,377,547.2	92,522,163.8
210302	Түлш, халаалт	247,901,840.8	310,959,551.0
210303	Цэвэр, бохир ус	50,804,050.0	49,477,472.0
2104	Хангамж, бараа материалын зардал	92,314,800.5	143,611,930.2
210401	Бичиг хэрэг	3,559,850.0	918,900.0
210402	Тээвэр, шатахуун	77,837,154.0	125,831,997.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,533,846.5	3,442,993.0
210404	Ном, хэвлэл	2,565,750.0	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.0	2,822,340.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,578,200.0	10,595,700.0
2105	Нормативт зардал	278,148,397.6	267,379,849.7
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,262,200.0	3,653,950.0
210502	Хоол, хүнс	275,886,197.6	263,725,899.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	281,043,400.0	99,764,700.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	8,457,500.0
210602	Тавилга	400,000.0	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	6,721,500.0
210604	Урсгал засвар	280,643,400.0	84,585,700.0
2107	Томилолт, зочны зардал	68,548,500.0	693,975,865.5
210701	Гадаад албан томилолт	-	11,128,365.5
210702	Дотоод албан томилолт	68,398,500.0	682,847,500.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	150,000.0	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,744,716.7	34,351,532.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,071,000.0	23,200,100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,005,338.7	4,221,932.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,090,000.0	2,266,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	891,000.0	3,151,200.0
210807	Газрын төлбөр	687,378.0	1,512,300.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,952,789.0	46,937,640.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,895,409.0	3,848,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,057,380.0	43,089,640.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,807,492.6	34,494,700.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,350,000.0	23,855,600.0
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	16,326,600.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,350,000.0	7,529,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,457,492.6	10,639,100.5
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,896,992.6	8,659,100.5
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	9,560,500.0	1,980,000.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	61,200,200.0	213,031,334.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	61,200,200.0	213,031,334.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	61,200,200.0	213,031,334.5
2200	Дотоод эх үүсвэрээр	61,200,200.0	213,031,334.5
220001	Барилга байгууламж	13,700,200.0	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	47,500,000.0	213,031,334.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(61,200,200.0)	(213,031,334.5)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,892,403,369.3	6,198,125,483.7	3,071,029,684.3	11,161,558,537.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Залруулсан үлдэгдэл	1,892,403,369.3	6,198,125,483.7	3,071,029,684.3	11,161,558,537.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
ХО-ын өсөлт, бууралт				
Цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн цэвэр орлого				
Тайлант үеийн үр дүн	-	-	963,709,216.0	963,709,216.0
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,892,403,369.3	6,198,125,483.7	4,034,738,900.2	12,125,267,753.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Залруулсан үлдэгдэл	1,892,403,369.3	6,198,125,483.7	4,034,738,900.2	12,125,267,753.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
ХО-ын өсөлт, бууралт				
Цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн цэвэр орлого				
Тайлант үеийн үр дүн	-	-	1,512,254,660.7	1,512,254,660.7
2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,892,403,369.3	6,198,125,483.7	5,546,993,560.9	13,637,522,413.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	8,121,979,000.0	8,109,234,700.0	12,744,300.0	99.8
122005	Төсвөөс санхүүжих	8,121,979,000.0	8,109,234,700.0	12,744,300.0	99.8
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,121,979,000.0	8,100,575,600.0	21,403,400.5	99.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,121,979,000.0	8,100,575,600.0	21,403,400.5	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,095,347,400.0	8,080,720,000.0	14,627,400.5	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,982,249,000.0	6,981,243,214.0	1,005,786.0	100.0
210101	Үндсэн цалин	4,283,098,200.0	4,269,937,727.0	13,160,473.0	99.7
210102	Нэмэгдэл	2,505,205,700.0	2,359,742,987.0	145,462,713.0	94.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	71,137,000.0	103,508,000.0	(32,371,000.0)	145.5
210104	Урамшуулал	122,808,100.0	248,054,500.0	(125,246,400.0)	202.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	168,970,000.0	168,186,384.0	783,616.0	99.5
210201	Тэтгэврийн даатгал	19,677,200.0	26,429,834.0	(6,752,634.0)	134.3
210202	Тэтгэмжийн даатгал	2,949,300.0	3,109,392.0	(160,092.0)	105.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,510,400.0	1,551,395.0	(40,995.0)	102.7
210204	Ажилгүйдлийн даатгал	1,580,400.0	1,269,717.0	310,683.0	80.3
210205	Эрүүл мэндийн даатгал	143,252,700.0	135,826,046.0	7,426,654.0	94.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	452,959,400.0	452,959,186.8	213.2	100.0
210301	Гэрэл, цахилгаан	89,955,500.0	92,522,163.8	(2,566,663.8)	102.9
210302	Түлш, халаалт	309,757,700.0	310,959,551.0	(1,201,851.0)	100.4
210303	Цэвэр, бохир ус	53,246,200.0	49,477,472.0	3,768,728.0	92.9
2104	Хангамж, бараа материалын зардал	20,381,900.0	17,779,933.0	2,601,967.0	87.2
210401	Бичиг хэрэг	3,411,600.0	918,900.0	2,492,700.0	26.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,443,000.0	3,442,993.0	7.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,823,600.0	2,822,340.0	1,260.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,703,700.0	10,595,700.0	108,000.0	99.0

2105	Нормативт зардал	238,644,400.0	238,643,350.0	1,050.3	100.0
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	3,655,000.0	3,653,950.0	1,050.0	100.0
210502	Хоол, хүнс	234,989,400.0	234,989,400.0	0.3	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	195,173,700.0	195,173,400.0	300.0	100.0
210601	Багаж, техник хэрэгсэл	10,000,000.0	9,999,900.0	100.0	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	6,721,700.0	6,721,500.0	200.0	100.0
210604	Урсгал засвар	178,452,000.0	178,452,000.0	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,659,900.0	19,887,432.0	9,772,468.0	67.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,395,000.0	8,736,000.0	8,659,000.0	50.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,527,200.0	4,221,932.0	305,268.0	93.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,266,000.0	2,266,000.0	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,159,400.0	3,151,200.0	8,200.0	99.7
210807	Газрын төлбөр	2,312,300.0	1,512,300.0	800,000.0	65.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,309,100.0	6,847,100.0	462,000.0	93.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,828,000.0	3,828,000.0	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,481,100.0	3,019,100.0	462,000.0	86.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,631,600.0	19,855,600.0	6,776,000.0	74.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,631,600.0	19,855,600.0	6,776,000.0	74.6
213203	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,326,600.0	16,326,600.0	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,305,000.0	3,529,000.0	6,776,000.0	34.2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,026,701,637.2
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,026,701,637.2
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,347,077.0
350014	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	856,793,060.2
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,560,500.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,024,721,637.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,024,721,637.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,020,721,637.2
2104	Хангамж, бараа материалын зардал	125,831,997.2
210402	Тээвэр шатахуун	125,831,997.2
2105	Нормативт зардал	28,736,500.0
210502	Хоол, хүнс	28,736,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	108,913,634.5
210601	Багаж, техник хэрэгсэл	61,241,134.5
210604	Урсгал засвар	47,672,500.0
2107	Томилолт, зочны зардал	693,975,865.5
210701	Гадаад албан томиллолт	11,128,365.5
210702	Дотоод албан томиллолт	682,847,500.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,173,100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,173,100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,090,540.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	40,070,540.0

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,000,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,000,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,980,000.0

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **57,751.9** мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг бүрэн залрууллаа. Үүнд:

1. ОБЕГ-ын даргын тушаалаар суралцах чөлөөтэй байгаа албан хаагчид тушаалд заагдаагүй 1,862.0 мянган төгрөгийн хоолны мөнгийг олгосныг нөхөн суутгуулсан,
2. Эд хариуцагчийн картыг шинэчлэн хөтлүүлсэн,
3. Жилийн эцсийн тооллогоор илэрсэн 55,889.9 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд нөхөн тусгуулсан.

Аудитаар нийт **35,850.0** мянган төгрөгийн 4 зөрчил² илэрч, 35,850.0 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөрчилд зөвлөмж өгөв.

5.1 Албан шаардлага:

5.1.1 Тус газраас “М.Батхааны дурсгалын хүрэл цутгуур, бичвэр бүхий чулуун дурсгалын гэрэлт самбар бүтээх” гэрээг “Арт вэй ХХК”-тай байгуулан **19,850.0** мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь “..... төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”, 13.3.1: “**хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах**” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.1.2 Ангиллын сургалт, сурталчилгаа урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан орон тооны 3 албан хаагчтай боловч гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, мэдээ мэдээлэл дамжуулах болон контент бэлтгэх, сошиал орчинд зар мэдээ тавих ажлыг гүйцэтгүүлэхээр “Сэлэнгэ шүтээн ХХК”-тай **3,000.0** мянган төгрөгийн гэрээ байгуулж, санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4 дэх “... байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

5.1.3 13,000.0 мянган төгрөгийн “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ” хийх зөвлөх үйлчилгээний гэрээг “Лидер грийн консалтинг ХХК”-тай байгуулж, урьдчилгаа төлбөрийн баталгаагүйгээр гэрээний урьдчилгаанд 5,200.0 мянган төгрөг, ажлыг комиссын актаар хүлээн аваагүй байхад үлдэгдэл төлбөр болох 7,800.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3 дахь “Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.29 дэх “Төсөл, арга хэмжээний эцсийн буюу бүрэн санхүүжилтийн хүсэлтэд гэрээг дүгнэсэн ... “Гэрээ дүгнэх маягт”-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд эх хувиар хавсаргаж ирүүлнэ”, 4.11.6 дахь “Зөвлөх үйлчилгээний зардлыг олгох санхүүжилтийн баримт бичигт гэрээний эх хувь,хүлээн авсан акт заавал хавсаргана”, 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн ГЭҮ-25 дугаар гэрээний 4.2 дахь “гүйцэтгэгч гэрээт ажлыг гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоногийн дотор эхлүүлж, ажлын 45 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Урьдчилгаа төлбөрийн баталгаа болон комиссын актыг үндэслэн санхүүжилтийг олгож байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Ашиглалтын явцад эвдэрсэн эд хөрөнгийг өмч хамгаалах Байнгын зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэрлээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно”, 1/: “худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх”, 2/: “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ОБЕГ-ын даргын тушаалаар суралцах чөлөөтэй байгаа албан хаагчид тушаалд заагдаагүй хоолны мөнгийг олгосон.	1	1,862.0			1	1,862.0	1	1,862.0				
Эд хариуцагчийг картыг шинэчлэн хөтлөөгүй.	1	-			1	-	1	-				
Жилийн эцсийн тооллогоор илэрсэн 55,889.9 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгасан	1	55,889.9	1	55,889.9								
Дүн	3	57,751.9	1	55,889.9	2	1,862.0	2	1,862.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин М.Батхаан-ы нэрэмжит хөшөөг барих гэрээ байгуулан, санхүүжилт олгосон	1	19,850.0			1	19,850.0						
"Сэлэнгэ Шүтээн" ХХК-иар гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, мэдээ мэдээлэл дамжуулах болон контент бэлтгэх зориулалтаар гэрээ байгуулж, санхүүжүүлсэн байна.	1	3,000.0			1	3,000.0						

"Гамшгийн эрсдэлийн үнэлгээ" хийх зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан, санхүүжилт олгосон боловч ажил бүрэн хэрэгжээгүй	1	13,000.0			1	13,000.0						
Ашиглалтын явцад эвдэрсэн эд хөрөнгийг өмч хамгаалах Байнгын зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэрлээгүй	1	-					1	-				
Дүн	4	35,850.0			3	35,850.0	1	-				